

Исаиагийн бошиглолын онцлог шинж чанарууд

“Исаиагийн бошиглол” бүтээлийн үндсэн агуулга нь энэхүү эртний бичвэрүүдтэй холбоотой нууцлаг зүйлсийг илрүүлэн гаргахад оршино. Эдгээрт утга зохиолын дүн шинжилгээг хийхэд бүтэц, хэв шинж, уран яруу илтгэх байдлын хувьд тус бүр өөрийн гэсэн өвөрмөц ойлголт, өгөгдөл, мэдэгдлийг гарган харуулж байсан болно.

1. Исаиагийн бошиглол цаг хугацааны хоёр үеийг нэгэн зэрэг хамааруулдаг

Иерусалимд эртний еврей хэлний сургууль (Rabbanic)-д намайг сурч байх үед сургуулийн удирдлага Исаиагийн бичвэрүүдийг (1) Исаиагийн өдрүүд; (2) “Хожмын өдрүүд” буюу “төгсгөлийн цаг хугацаа” (‘aharithayyamim) хэмээн цаг хугацааны хоёр өөр үеийг нэгэн зэрэг хамруулан заасан юм. Энэ талаар хэрхэн мэдэж буйг намайг асуухад тэрээр ямар ч нотолгоо байхгүй, харин энэ бол Жүүдүүдийн уламжлал байсан гэж хариулсан билээ. Хэдэн жилийн дараа докторын судалгааны ажил хийж байх үедээ Исаиагийн номын уран зохиолын бүхий л бүтцээс энэхүү нотолгоог олж мэдсэн юм. Эдгээр нь Исаиагийн номыг шинжлэн судлах аргыг бүхэлд нь өөрчилсөн билээ. Исаиагийн өдрүүдээр эхэлж буй олон зууны туршийн үйл явдлуудын мөчлөгийг шугаман бүтцээр дүрсэлж зураглав. Мөн түүнчлэн уг зураглалыг зэрэгцүүлсэн бүтцээр үечилж, төгсгөлийн цаг хугацааны үйл явдлуудыг нэмж өгсөн юм. Эдгээр нь Исаиагийн номыг бүхэлд нь нэг үйл явдал болгоно. Уг үйл явдлуудын цаг хугацаа нь хожмын өдрүүд буюу төгсгөлийн цаг үеийг хүртэл хамардаг.

Энэ бүхэн биднийг Исаиагийн номын сургаалд гардаг төгсгөлийн цаг үеийн талаарх өөрсдийн бодлоо өөрчлөх ёстойг ойлгуулдаг. Иоханы адил дэлхийн төгсгөлийг Исаиа үзэгдэлд харсан. Утга зохиолын зэрэгцүүлсэн бүтэц нь түүний номыг ертөнцийн төгсгөлийг үзүүлсэн бошиглол болгон өөрчилсөн. Гэвч энэхүү ном түүний амьдарч байсан үеийн үйл явдал, мөн түүнээс хойших цаг үеийн түүхэн дээр суурилсан байв. Гол асуудал нь тэдгээр эртний гүрнүүд хожмын цаг үетэй хэрхэн холбогдох вэ? Хэдийгээр одоо оршин тогтнохоо больсон ч тэдгээр улс гүрнүүдийн нэр алдар хожмын өдрүүдэд бичигдэх болов уу? Үүнд хариулахад эртний нэрсийн үүрэг нь төгсгөлийн цаг хугацааны үед нууц нэрс байх болно. Тэдгээр улс гүрнийг өнөөдөр оршин байгаа улс, үндэстнүүдийн нэртэй хольж хугтах, эсвэл Исаиагийн бошиглолыг зөвхөн Ойрхи Дорнодын газарзүйн байрлалд хамаатуулан ойлгох нь өрөөсгөл юм.

Үнэн хэрэгтээ Исаиагийн нууц нэрсийн утгыг олох нь энгийн юм. Исаиагийн дүрсэлснээр түүний өдрүүдэд оршин тогтнож байсан улс гүрнүүд өнөөгийн дэлхийн улс гүрнүүдтэй таардаг. Жишээ нь Египет улс түүний үед агуу том гүрэн байв. Гэсэн хэдий ч тухайн үедээ эдийн засаг, улс төр, шашны хувь аажмаар уналтанд орсон байна. Түүнээс өмнө Египет өөр нэг агуу гүрэн болох Ассирийн хаант улсын эсрэг дайтаж байсан юм. Ассири нь тухайн цаг үедээ Умардад орших цэргийн хүчирхэг гүрэн байсан бөгөөд цагтаа дэлхийг эзлэхийг эрмэлзэж байсан ба энэ нь бодит байдлын хувьд биелсэн билээ. Тиймээс Исаиа эртний Ассирийн сүйрлээр дэлхийн төгсгөлийг ёгтолж хэлсэн байдаг. Өнгөрсөн цаг хугацаанд юу тохиосон, тэр бүгд дахин ирэх бөгөөд энэ нь зөвхөн өнөө үеийн шинэ “Ассири” болон шинэ “Египет” –ээр тохиох болно.

Бусад үндэстэн болон хүмүүсийн хувьд ертөнцийн төгсгөлийн үед хүлээх үүрэг нь ижил тэгш, адил байна. Исаиа, тэд хэн болохыг тодорхойлж хэлсэн байдаг. Яг л

сөргөлдөж буй улс төрийн хоёр тал адил шинэ “Ассири” болон “Египет” гарч ирэх бөгөөд түүнчлэн сөргөлдөж буй сүнслэг хоёр тал адил шинэ “Вавилон” болон “Сион” гарч ирнэ. Вавилоны ард түмэн болон тэдний байх газар нутгийг Исаиа тодорхойлохдоо: ёс бус зүйлд боловсорч буй дэлхий ба түүний ялзарч буй оршин суугчдаар дүрсэлжээ. Бурхан тэднийг Содом болон Гоморраг устгадаг шиг устгах болно. Исаиа мөн Сионы ард түмэн болон тэдний газар нутгийг тодорхойлохдоо: ёс бус зүйлээ наманчилсан, цөллөгөөс буцаж ирэгсэд, ертөнцийн төгсгөлд Сион руу дүрвэх тэд болно гэжээ. Энд Исаиа уран зохиолын дүрслэлээр дэлхийн бүх хүмүүсийг тодорхойлж хэлсэн байдаг. Түүнийг зөвхөн Еврей хүмүүст хамаатуулж хэлсэн гэж бодвол эндүүрэл болох юм.

2. Исаиагийн гэрээ, шашны номлол, хаант улс болон харьяат нарын харьцуулалт

Магадгүй бид Еврей бошиглогчдыг олон санааг харьцуулан боддог шинийг санаачлагч, эсвэл эртний Грекийн фиолософичтой адилтган толгой эргэж магадгүй юм. Бошиглогчид хэдийгээр амьдралыг маш олон боломжит санаагаар заадаг ч өөрсдийн эргэцүүлэх хүчээр амьдралын учрыг олох гэж оролддоггүй. Харин тэд сүнслэг өвийг тэнгэр болон газрыг бүтээгч Бурханаас ирсэн илэрхийлэлтийн суурин дээр бий болгодог. Тэд, уг суурин дээр Бурханыг ойлгох ойлголт, хүн төрөлхтөн болон мөнх байдлын тухай ойлголтыг гүнзгийрүүлэн бий болгодог. Одоог хүртэл, эртний ойрхи Дорнодын хаант улс түүний харьяат нарын үзэл бодол, бошиглолууд Бурхан болон хүн хоорондын харилцааг тодорхойлоход хэрэглэж байсан эдгээр гайхалтай эх сурвалжуудыг эсэргүүцсэн байдал харагдсаар байна. Учир нь Хаант улс ба түүний харьяат улсын загвар бол Израилын сургаал, шашны номлолын гол хэсэг байсан ба эдгээр нь Бурханаас үүдэлтэй байж болох уу?

Эртний Ойрхи Дорнодын Хаант улс болон түүний харьяат орны харилцаа нь хаант улс нь харьяатаа захиран томилно, эсвэл харьяатууд хаант улсын дор өөрийн хуулийн засаглалаар улсаа удирдана. Хаант улс бүх харьяатаа өөрийн хаант улсын хэсэг байлгаж, хааны хувьд удирдана. Хот улсын бүрэлдэхүүн түүний хаяа нийлсэн хот суурин болон тосгодоос бүрдэх эдгээр “амлагдсан нутаг” нь эвслийн гэрээ, эсвэл гэрээ хэлцлийн үндсэн дээр хаант улсын харьяат болдог байв. Гэрээ хэлцэл нь тодорхой нөхцөлүүдтэй бөгөөд харьяатууд хаант улсдаа үнэнч байх, өөр хаант улстай харилцах харилцаандаа өөрчлөлт гаргахгүй байх зэрэг үүрэгтэй. Эвслийн гэрээнд, харьяат орон гэрээнд заасны дагуу тушаал зааврыг дагаж чадвал, хаант улсаасаа “таалал” олж авна гэж заадаг байв. Адислал, эсвэл хараал хүртэх нь харьяат орон гэрээндээ дуулгавартай, дуулгаваргүй байхын аль алинаас нь тус тус хамаарна.

Мөн “Хаадын хаад” болон “ноёдын ноёны” хувьд, үнэнч харьяат орон бодит аюултай тулгарахад хаант улсын дайчид цугларан харьяат орныг хамгаална. Харьяат улсад аюул учруулсан хэн боловч Хаант улс болон харьяат улсын “хамтын дайсан” гэж нэрлэгдэх бөгөөд тэд үхлээр төгсөх учиртай. Удаан хугацааны турш өгөгдсөн бүх нөхцөлийн дагуу харьяат орнууд хаант улсдаа үнэнчээ баталбал хаант улс харьяат орноо өөрийн “хүү” хэмээн албан ёсоор хүлээн авдаг. Энэ мөчид хаант улс болон харьяат орны харилцаа “эзэн-зарц” гэсэн харилцаанаас “эцэг-хүү” гэсэн харилцаанд шилждэг. Үүнээс өмнө харьяатын эзэнт улстай байгуулсан гэрээ нөхцөлтэй байх ба харьяатууд эзэнт улсдаа хэр үнэнч байхаас хамаардаг. Харин одоо энэхүү гэрээ нөхцөлгүй, эсвэл “мөнхийн” болох бөгөөд түүний хойч үе адислагдсан өв хүртэгчид болдог.

Хаант улс болон харьяатын хуулийг дагасны төлөө харьяатын ард түмнийг хаант улс хамгаалах үүрэгтэй. Энэ нь Израилын ард түмэн Филистчүүдийн гарт орж мөхөхөд ойртсон үед Израилын ахмад настнууд хаандаа хүсэлт гаргадагтай адил юм. Бурхантай гэрээ байгуулсан Давид хаан үүнийг дагасан бөгөөд Бурханы хамгаалалтыг олж авсан байдаг. Энэ нөхцөлд хаан Бурханы харьяат болж Бурхан Израилын хамгаалагч болдог. Бид Хаан Хезекиа болон түүний хүмүүс Ассирийн армийн 185 мянган цэрэгт эзлэгдэж, мөхөх аюултай тулгарсан үед Исаиагийн номын Давидын гэрээгээр хамгаалагдсаныг мэднэ. Хезекиа Бурханы зарлигийг дуулгавартай дагадаг байсан бөгөөд мөн түүний хүмүүс Хезекиагийн зарлигийг дагаснаар Бурханы элч нар Ассирийн дайчдыг нэг шөнийн дотор устгадаг.

3. Исаиа өмнө нь тохиож байсан түүхийн үйл явдлыг ирэх зүйлсийн хэв шинж болгов

Та Еврей бошиглогчид Бурханы өгсөн илэрхийлэлтийг тодорхой бичин үлдээсэн, эсвэл өөрсдийнхөө бодол, үзэл санааг нэмсэн гэж боддог уу? Жишээ нь, Исаиа бол үнэхээр Бурханаар урамшуулагдсан, уран сэтгэмжтэй бичдэг агуу бошиглогч байв. Түүний бичвэрүүд нэлээд олон давхар шаталсан, утга зохиолын арга барилыг үзүүлдэг. Эдгээр бошиглолын арга зам нь тэрээр өөрт нь ирсэн илэрхийлэлтүүдийг хэрхэн гайхалтай замаар цэгнэн дэнсэлснийг харуулдаг. Тэдгээр санаа, зорилго цөөн үгээр үнэнтэй холбогдож байсан бөгөөд Исаиа бичвэрээ эртний ойрхи Дорнодын утга зохиолын бүх загвараар бичсэн боловч өөрийнхөө бошиглолын зорилгод нийцүүлсэн байдаг. Тэр хэдийгээр түүнээс өмнө байсан бошиглогчдын суурин дээр түшиглэн бичиж байсан боловч түүнээс өмнө байсан мөн түүний дараах бошиглогчдын хүрээнээс хальсан байв. Зарим хүмүүс нэгээс олон “Исаиа” байсан гэдэг боловч түүний утга зохиолын шаталсан онцлог нь үүнийг үндэслэлгүй болохыг харуулдаг.

Исаиагийн утга зохиолын арга барилын нэг нь төгсгөлийн цаг хугацааны үйл явдлыг урьдчилан таамаглахдаа эртний үйл явдалтай нэн төстэй байдлаар харуулсан явдал юм. Үнэндээ Исаиа уг бошиглолын арга замыг байнга хэрэглэхээс өөрийгөө хязгаарладаг байсан. Энэ утгаараа Исаиагийн зөгнөлүүд Еврей бошиглолын уламжлал дээр суурилсан байдаг бөгөөд үүнтэй ижил төстэй байдал үргэлж харагдана. Бодит байдал дээр өнгөрсөнд тохиолдсон юу ч байсан ирээдүйн төлөв загвар буюу хэв шинжийг тодорхойлж болно гэсэн үг юм. Ийм арга замаар Исаиа өөрийн зөгнөлөө гаргаж ирсэн байдаг. Тэрээр эртний хүмүүс, улс гүрний нэрийг дурдахдаа уг хүн эсвэл улс гүрэн урьд нь байснаараа төгсгөлийн цаг хугацааны зарим нэг загвар жишээ болдог. Бид, түүх давтагддаг гэж хэлэлцдэг. Гэхдээ өнгөрсөнд давтагдсан бүх зүйл тэрхүү загварыг даган замнадаггүй бөгөөд харин тэрээр дахин давтагдах магадлалтай, ижил төстэй түүхийн хэсгээс сонгодог байв.

Исаиагийн бичиглэлд эртний үйл явдлын гуч гаруй шинэ хувилбар гардаг ба бүхий л томоохон үйл явдлууд нь Израилын түүхэнд давтагдаж байна. Хэдийгээр Исаиа тэдгээр зөгнөлүүдийг өөрийн номондоо тараан байрлуулсан боловч тэдгээрийг даалуу өрөхтэй адил холбоос хийсэн байдаг. Жишээлбэл, нэг бүлэгт хэд хэдэн үйл явдлын холбоос багтсан байхад өөр бүлэгт өөр төрлийн холбоосыг хэрэглэнэ. Төгсгөлд нь эдгээр нь бүгд тайлбарлагдсан байдаг ба үүнд: шинэ шинэ эмх замбараагүй байдал, бүтээлт, диваажин, Содом болон Гоморрагийн сүйрэл, боолчлол, дээгүүр өнгөрөх баяр, дүрвэлт, цөл дэх тэнүүчлэл, газар нутгийн булаан эзлэлт, ариун сүмийн сэргээн босголт гэх мэт цааш үргэлжилнэ. Хэдийгээр эдгээр үйл явдал дахин тохиох боловч төгсгөлийн цаг үеийн агуу үзэгдэлд Израилын түүхийг дэлхий дурсан санах ба тэдгээрийн дарааллууд

нь өөр байна. Чухамдаа тэрхүү агуу үзэгдэл нь “төгсгөлийн цаг хугацааг” тодорхойлдог.

Исаиагийн зөгнөлд байдаг энэхүү түүхийн давтагдал бүх хүн төрөлхтөнд хамаатай юм. Гэвч энэ нь Исаиагийн хувилбар биш. Хүмүүний төсөөлөн харах зөгнөл өөр бөгөөд бидний өмнө юу хүлээгдэж байгааг мэдэх аргагүй, зөвхөн Израилын Бурхан л “эхлэлээс төгсгөлийг” урьдчилан хэлдэг (Исаиа 46:10). Тэр зөвхөн хүмүүний түүхийг ийм замаар удирддаг бөгөөд төгсгөл нь эхлэлд багтсан байдаг. Өнгөрсөн үйл явдлууд нь түүгээр улиран тохиогдсон бөгөөд өөрөөр хэлбэл төгсгөлийн цаг хугацааны үйл явдлуудын урьдчилсан шинж тэмдэг юм. Тэрхүү чадавхаар Израилын Бурхан өөрийн тэнгэрлэг гэдгийг нотолдог. Тэдгээр эртний үйл явдлууд дахин тохиоход хүмүүс цаашдаа Исаиагийн анхааруулгын талаарх тайлбарыг үл тоомсорлох хэрэг үгүй болно. Үнэндээ урьд өмнө байсан хүмүүс болон ирээдүйн үйл явдлуудын дүрслэлийн тухай дахин нотлох нь худал хуурмаг зүйлсийг ялган танихад тусална. Тэдгээр зүйлс нь өнгөрсөнд тохиосон үзэгдлүүдээс гажсан Бурханы бус зүйлсүүд болно.

4. Исаиа хүмүүсийн шинж чанарыг сүнслэг долоон түвшингээр илэрхийлдэг

Исаиагийн бичвэрт гардаг хүмүүс эгэл жирийн, тохиолдлын бусаар үзэгддэг нь таныг гайхшруулдаг уу? Хэдийгээр Исаиа өөрийн амьдарч байсан үеийнхээ хүмүүсийг дүрслэн бичсэн боловч эдгээр нь мөн төгсгөлийн цаг үед байх тэдгээр хүмүүсийн ажил үүрэгтэй төстэй байхаар дүрслэгддэг. Мөн түүнчлэн тэд өөр өөр сүнслэг зэрэглэлийн жишээгээр дүрслэгддэг билээ. Исаиа, Бурханы гэрээт хүмүүсийг “Иаков” болон “Израил”, зарим үед “Сион” болон “Иерусалим” гэсэн холбоо үгс хэрэглэн бичсэн байдаг. Ялгаа нь юу юм бол? Илүү гүнзгий харвал Иаков болон Израил гэсэн нэрээр Бурханы хүмүүс дотроос эд баялгийг шүтдэг бүлэглэлийг дүрсэлжээ. Хуурамч шүтээн нь сүнслэг байдлын хувьд тэднийг харалган болгодог ба тэд энэ байдлаасаа сэрэх хэрэгтэй бөгөөд дэлхийд удахгүй ирэх Бурханы шүүлтийн өдөр аврагдаж чадахгүй.

Үнэн хэрэгтээ Иаков/Израилын зэрэглэлийн хүмүүс уруудаж, дарангуйлагч, ёс бусыг үйлдэгч Вавилоны хүмүүсээс ч дордох магадлалтай. Бурханы сорилт ирэхэд итгэлээ хадгалдаг, үнэнч, нүглээ наманчилдаг бүлэг хүмүүс нь Сион/Иерусалим руу өгсөж буй хүмүүс болно. Тэд ийн үйлдсэнээр Бурхан тэдний нүглийг өршөөж өөрийн гэрээт хүмүүс хэмээн хүлээн зөвшөөрдөг. Бошиглогч Исаиа цааш нь төгсгөл ирэхэд дэлхий хоёр туйлд хуваагдан юу тохиож болох талаар хэлжээ. Бурханы шүүлтийн өдөр ирэхэд Вавилоны зэрэглэлийн бүх хүмүүс дэлхийгээс арчигдана. Бурхан зөвхөн Сион/Иерусалим болон түүний түвшнээс дээгүүр хүмүүсийг гэтэлгэнэ. Эдгээрийн дундах Иаков/Израилын бүлэг нь бусад бүх дунд хэсгийнхэн шиг мөхөн алга болно. Энэ түвшний хүмүүс Сион/Иерусалим руу өгсөх үү эсвэл Вавилон руу уруудах уу гэсэн сонголттой нүүр тулна.

Сион/Иерусалимаас дээш зэрэглэлд Бурханы “зарц” болон “хүү” багтана. Хувь хүний гэрээний харилцаагаар Бурханд үйлчилснээр зарим нь Сион/Иерусалимын зэрэглэлд орох бөгөөд цаашдын сүнслэг түвшин рүү өгсөнө. Бурханы зарц болон хүүгийн зэрэглэл бүхэлдээ төгсгөлийн цаг хугацааны үеийн дэлхийг засаглах Иеховагийн ирэлтийн замыг бэлтгэх номлолын ажлын үр дүнд гарч ирнэ. Мосе Израилын ард түмнийг Египетээс амлагдсан нутаг руу удирдан аваачсантай адил түр зуур ирсэн аврагчийн хувьд Бурханы зарц нь бүх үндэстнүүдийг шинэ дүрвэлт рүү удирдан Сион

руу хүргэнэ. Бурханы зарц нар болон хөвгүүд тэдгээрийн Хаан буюу Израилын Бурхантай хийсэн болзол бүхий гэрээнд өгсөн дээшилдэг. Энэ бүх гэрээний нөхцөлд тэд үнэнч байвал уг гэрээний нөхцөл болзолгүй болж, тэд түүний сонгогдсон нэгэн болно.

Эдгээр нь ингээд зогсохгүй. Хүү болон эзний зарцын дээр сахиусан тэнгэр/аврагч орших бөгөөд тэд тэнгэрлэг төлөөлөгч лугаа адил үйлддэг. Тэдний дээр Иехова буюу Израилын Бурхан бөгөөд Сионы Хаан оршино. Исаиа энэхүү сүнслэг шат дарааллын өсөлт бүрийг тухайн өсөж буй хүний дахин төрөлт эсвэл дахин бүтээлтээр дүрсэлсэн байдаг. Дээшлэх бүх шат дараалалдаа тухайн хүн шинэ нэр хүлээн авч мөн илүү өндөр түвшний сүнслэг тохинуулалд зориулагддаг. Энэ бүх шатуудад гэрээтэй холбоотой илүү өндөр хуулийг дагадаг. Үүнээс гадна өгсөх бүх дараалал түр зуурын бууралтыг агуулдаг. Энэ нь Бурхан тухайн хүний үнэнч эсэхийг шалган сорилтуудыг шат дараатай өгснөөр тохиодог. Иймэрхүү сорилтууд уруудах чиглэлд байгаа хүмүүст ч тохиох нь бий. Мөхлийн хамгийн доод түвшний хүмүүс нь чөтгөрийн зүйлсийг бодож олдог мөн зохион байгуулдаг тэдгээр юм.

5. Исаиа хоёр өөр төрлийн бурханлаг (Messianic) бошиглол үзүүлдэг

Олонх хүмүүс бүх Бурханлаг бошиглолууд адилхан хэмээн боддог. Гэсэн ч энэ нь тийм биш юм. Энд маш чухал ялгаанууд байдаг. Еврей болон Христэд итгэгчид Мессиагийн талаар яагаад хамт суугаад судалдаггүй вэ? Еврейчүүд судруудаа маш сайн мэддэг. Бурханлаг бошиглолууд тэднээс л үүдэлтэй. Тэдний гэгээлэг, хамгийн ухаалаг эрдэмтэд үеэс үед дамжин ирсэн бошиглолын бичвэрүүдийг цөхрөлтгүй, итгэлтэйгээр судалж ирсэн. Нөгөө талаар харийнхан гэж хэлэгддэг Христэд итгэгчид эдгээр бошиглолуудыг бий болгоогүй. Одоог хүртэл тэдний Мессиа болох Есүст итгэлтэйгээр үйлдэх үйлдэл нь тэдний хийх бүх зүйл хэмээн үздэг бөгөөд хэрэв тэд Еврей судруудыг өмчлөх эрхтэйгээр ямар ч хэлэнд хөрвүүлж, сургаал болгон заах нь тухайн цаг үедээ тэдэнд тохиромжтой байдаг.

Цаашилбал, Исаиа хоёр өөр бодьгал болон тэдний хоёр өөр янзын Бурханлаг үүрэгтэй тухай бичсэнийг та бүхэн олж харна. Нэг нь зуурдын, нөгөө нь сүнслэг. Мөн бошиглолын нөхцөл байдлыг сайн анхаар. Нөхцөл байдлаас өөр зүйлийг гаргаж ирэх нь Харийнханы хийдэг нэг зүйл. Бурхан өөрийн “зарц”-ын тухай ярих нэг жишээ, “хүү”-гийнхээ тухай ярих бас нэг өөр жишээний тухай ярилцъя. Эдгээр жишээний нөхцөл байдал нь Израилын төгсгөлийн цаг үеийн дахин сэргээлт бөгөөд уг үйл явдал цаг зуурын шинжтэй. Энэ нөхцөлд Бурхан хоёр өөр хүний тухай яриагүй, харин зөвхөн нэг хүнийг дурьдсан. Албат харьяатын эзэнтэйгээ харилцах харилцааг тодорхойлохдоо ялангуяа эзний зарц болон хүү нь салангид бус бөгөөд үргэлж хамтдаа ойлгогдоно. Түүнчлэн Мосегийн хувьд Бурхан өөрийн хүмүүсийг удирдахын тулд олон бошиглогчдыг нэгэн зэрэг дуудаагүй харин ганц түүнийг дуудсан юм.

Мөн түүнчлэн Бурханы зарц болон хөвгүүд хүмүүсийг боолчлолоос чөлөөлж, Израилын овгуудыг нэгтгэн, дайснаа байлдан эзэлсэн зэрэг Израилын төгсгөлийн цаг хугацааны үеийн дахин сэргээлтийн талаар Исаиагийн маш олон бошиглол байдаг талаар ярилцъя. Исаиа төгсгөлийн үеийг таамаглаж байхдаа Бурханы зарц болон хүүгийн өнгөрсөн үеийн хэв шинжийг хэрэглэхээс татгалзаж байсан бөгөөд өнгөрсөнд болсон бүх зүйлийг үйлдэж байсан нэг хэв шинжтэй хүнийг хаанаас олох боломжтой байсан бол? Үнэндээ хэн ч байгаагүй юм. Ийм учраас Исаиа өнгөрсөн үед олон удирдагчдын хийж байсан зүйлийг төгсгөлийн цаг үед нэг удирдагч биелүүлэх нэгдмэл

дүр төрхийг бий болгосон. Бурханы хүмүүс буюу Бурханы зарц болон хүү дахин сэргээлтийн үед хийх ажлаас гадна тэдний зан чанарын онцлогийг харуулсан юм. Тийм учраас Исаиа түүнийг дүрслэхдээ Абрахам, Мосе, Жошуа, Давид, Хезекиа болон Кореш нарын нэгдмэл хэв шинжээр үзүүлсэн байдаг.

Магадгүй та бүхэн Корешыг дурьдсан нь уг загварт тохирохгүй гэж бодож болох юм. Хэрэв анхааралтай ажиглавал Исаиагийн “Кореш” нь хэзээ ч бодит түүхэн хүн байгаагүй бөгөөд энэ бол нэгдмэл дүр юм. Жишээ нь Кореш болон Мосегийн дүр төрхийн нэгтгэсэн нэг жишээ (Исаиа 44:27-28), Кореш болон Давидын дүр төрхийг нэгтгэсэн өөр нэг жишээ (Исаиа 45:1) байдаг. Үнэндээ Исаиагийн 53:1-10 шүлэгт Бурхан өөрийн зарц болон хүүгийн тухай ярьдаггүй бөгөөд харин бид сүнслэг Мессиагийн дагалдагчийг олж хардаг билүү? Исаиагийн 53:1-10 шүлэгт Исаиагийн дүрсэлсэн тэр дүр бол дэлхийг захирах Иеховагийн ирэлтэд хүмүүсийг бэлтгэх Бурханы зарц болон хүүтэй адилгүй нэгэн болох Иехова өөрөө байсан. Мөн түүнийг Израилын Бурхан, Сионы Хаан хэмээн Исаиагийн 52-53-р бүлэгт тодорхойлсон байдаг бөгөөд энэхүү бүлгийг Исаиагийн 14-р бүлэгт гарах Вавилоны хаантай уран зохиолын зэрэгцүүлсэн загвараар харьцуулсан байдаг .

6. Исаиа төгсгөлийн цаг хугацааны хүмүүсийг өөр нэрээр зүйрлэн үзүүлэв

Еврей шашны багш, Исаиагийн дүрсэлсэн ариун амьтдыг Израилын Бурханы хүмүүс хэмээгээд харин ариун бусыг Харийнхан хэмээн иш татан заахад би мэл гайхан сууж билээ. Энэ нь шар болон илжиг, мөн арслан болон хурга хамтдаа орших мянган жилийн үе дэх зохицол адил шинэ утга санааг гарган ирсэн юм. Хэдийгээр багшийн заасан зүйлийг нэг бүрчлэн санахгүй байгаа ч тэрээр нүхэнд амтат жимсний үр суулгасан юм. Хожим нь би Исаиагийн номонд нэг зүйл нөгөө утгыг урнаар зүйрлэн үзүүлж буй ойролцоо утгатай зэрэгцээ мөрүүдийн сүлжээ байгааг олж мэдсэн юм. Нэг шүлэг олон утгыг илэрхийлж болох бөгөөд жишээлбэл, мод хүмүүсийг төлөөлдөг бол, ой мод хотуудыг, уул нурууд нь үндэстнүүдийг гэх мэтээр үргэлжилнэ. Төгсгөлийн үеийн хүмүүсийн онцлог нь Бурханы шинж чанарыг биечлэн үзүүлэх болохыг би олж мэдсэн юм. Жишээ нь зөв шударга байдал болон гэрэл гэгээ, нөгөө талаас уур омог болон хилэн мөн бусад.

Гэхдээ яагаад Исаиа ийм шууд бус арга замаар ярьсан юм бол? Нэгдүгээрт, Исаиа төгсгөлийн цаг үеийн тухай зөгнөхдөө өнгөрсөнд тохиолдсон зүйлсийн хэв шинжүүдийг тэр бүр ашиглахыг зорьдоггүй байсан. Ийм учраас, эдгээр дүр төрх, хэв шинжүүд гараагүй үед тэрээр өөрийн хүссэн зүйлсийг хэлэх өөр замуудыг олох ёстой болдог байв. Хоёрдугаарт, Исаиа бүх зүйлийг яриагүй. Түүний үгийг гүн гүнзгийгээр судалж, итгэж чадах зөвхөн тэд түүний үгсийн утгыг ойлгох болно. Гуравдугаарт, утга авцалдаагүй мэт харагдах түүний бичвэрүүд нь түүнийг ойлгодог хүмүүсийг, ердийн өрөөсгөл хандлагатай уншигчдаас хамгаалдаг. Исаиагийн арга барил нь одоо ч түүнийг хамгаалдаг. Тэрээр өнгөрсөн үеийн ямар дүр төрх төгсгөлийн үеийн ямар үйл явдалд тохирохыг, мөн энэ нь урьд өмнө хаана ч тохиож байгаагүй гэдгийг хэрхэн мэдэж байсан бэ? Исаиа эдгээр саад тотгорыг зүйр үг хэллэг ашиглах, мөн уг нөхцөлд үйл явцыг гүйцэтгэгчид нууц нэр эсвэл өөр зохиомол нэр өгөх зэргээр даван туулж байсан юм.

Исаиа дэлхийн дөрвөн зүгт одсон Бурханы хүмүүс өмнө нь хэзээ ч боолчлолоос эргэж ирээгүйг мэднэ. Ассирийн агуу хаант улс шиг уналтанд орсныг ч мэднэ. Исаиа Израилын өнгөрсөн нөхцөл байдлын хүрээнд эдгээр зүйлсийг урьдчилан зөгнөж чаддаг. Тэрээр Иеховагийн ирэлтийн өмнө хүн төрөлхтөнд тохиох хоёр гол үйл явдлыг

зөгнөн мэдсэн байв. Үүнд: (1) Эзэрхэг түрэмгий Ассирийн Хаан - Сүйтгэгч, (2) Бурханы зарц болон хүү – Чөлөөлөгч. Шаардлагатай ямар ч үед Исаиа тэдгээр хүмүүсийг зохиомол нэрээр иш татаж байв. Эдгээр нь бамбар, гар, саваа, таяг тулгуур, үүд, дуу хоолой, гал түймэр, сэлэм зэрэг нь нөхцөл байдлаас шалтгаалан тус бүр бие даасан байдлаар зөгнөн тэмдэглэгдэж байв. Энэ бүхэн тус бүр өөрийн утгатай. Жишээ нь гэрэл болон харанхуй нь эсрэг тэсрэг хоёр зүйлийг илэрхийлдэг.

Эртний Ойрхи Дорнодын домог Исаиад нэмэлт эх сурвалж болж байсан юм. Баал болон Анаг нарын тухай Угаритын үлгэр домогт Тэнгисээр хөл үймээний бурханыг, Гол Мөрөнөөр байлдан дагуулагч, дайсан Баалыг дүрсэлдэг. Ассирийн хааныг өөр нэрээр нэрлэхэд эдгээр үг хэллэгийг хэрэглэх нь Исаиад тохиромжтой байв. Бурхан өөрийн таягаа тэнгисийн усан дээгүүр, харин гараа гол мөрөн дээгүүр өргөв, тухайлбал, төгсгөлийн цаг хугацааны үеийн Бурханы зарц болон хүү (түүний таяг болон гар) Ассирийн хааны (тэнгис болон мөрөн) дээр байгаагаар Бурханы ялалтыг онцлон харуулдаг. Бурханы уур хилэнг үзүүлснээр, энэхүү нүглийг захирагч нь ёс бусыг шийтгэхдээ бариул болон таяг адил үйлддэг. Эцэст нь Бурханы зарц болон хүү, түүний зөв шударгын бариул болон таяг нь түүнийг цохино. Эдгээр адилтгалуудын түлхүүр нь энэхүү үг хэллэгийн давхар утга санаануудыг бүтээх зэрэгцээ мөрүүдэд харагддаг.

7. Исаиагийн төгсгөлийн цаг хугацааны үеийн бошиглол эртний үлгэр домогтой ижил төстэй

Магадгүй та Исаиагийн бичвэрүүдийн юу нь үлгэр домогтой төстэй байдгийг сонирхдог биз. Хариулт нь бараг л бүх зүйл гэж ойлгож болно. Эдгээрийн нийтлэг зорилго нь сүйт залуу болон сүйт бүсгүй, тэнгэрлэг газар болон газар дэлхий дээр амар сайхандаа мөнхөд жаргахад байдаг. Гэсэн хэдий ч тэнд очихын тулд баатар эрэгтэй, эмэгтэй хоёр хэцүү хүнд зүйлсийг даван туулах ёстой бөгөөд тэдэнд өгөгдсөн өндөр оюун ухааны чадавхаас суралцах ёстой ба өөрийн оюунд түшиглэх ёсгүй байдаг. Тэд үүнийг хийхдээ итгэлтэй байх ёстой бөгөөд зарим тохиолдолд тэдний хувь заяа эргэж болно. Хэцүү цаг үе тэднийг хүрээлж, хараал болон зэмлэл буруушаал тэднийг зовоох бөгөөд энэ бүгд нь зорилгодоо хүрэхэд нь тэдэнд шаардлагатай туршлагауд болно. Үүнгүйгээр тэд зорилгодоо хүрч чадахгүй юм. Үнэндээ тэдний амьдралыг эргэн харвал тэд юуг ч өөрчлөхийг хүсэхгүй байх байсан.

Үлгэрт гардагчлан агуу мөнхийн амьдралд хүрэх замууд нь нулимсны зам мөр байх тохиолдол байдаг. Исаиагийн номын долоон хэсэг бүтэц нь үүнийг харуулдаг. Эдгээр эсрэг тэсрэг сэдвүүдийн долоон хослол нь мөнх амьдралын аз жаргалд хүрэх замыг үзүүлдэг бөгөөд үүнд дахин төрөхийн өмнө сүйрэл, авралын өмнө зовлон шаналал, мөнхийн өргөмжлөлийн өмнө доромжлол, өв залгамжлахын өмнө өв залгамжлалгүй болох гэх мэтээр үргэлжилнэ. Зөвхөн ганц удаа биш бүх цаг үед хүмүүн дээд түвшний сүнслэг үе шат руу дахин давтагдсан байдлаар өгсдөг. Тухайн хүн илүү өндөр хүч чадалд хүрэх нь түүний бурханлаг зөвлөмжийг хэрхэн зуурдын байдлын үедээ дагаж мөрдөхөөс хамаарна. Хэрэв ингэж чадвал үр дүнд нь сүйт залуу бүсгүй хоёр тэнгэрлэг оршихуйд төгсгөлгүй аз жаргалтай байх болно. Гэвч бүх хүн үлгэрт гардаг энэхүү агуу төгсгөлд хүрэх төлөөсийг төлөхийг хүсдэггүй.

Исаиагийн төгсгөл үеийн үзэгдэлд, Сионы Онгон Охин энэ түүхийн эмэгтэй баатар байдаг. Тэр нүглээ наманчилж, Израилын Бурханд гэрээний бүх нөхцөлийн доор үнэнч байснаар үзүүлдэг. Тэр түүний сүйт залуу Иеховатай хуримлаж “мөнхийн гэрээнд” орсон үеэс эхлэн энэ дэлхийг засаглана. Сионы хааны хувьд түүний хүмүүстээ бэлтгэсэн тэрхүү адил замаар алхсанаар тэр энэхүү алдрыг хүртэнэ. Сүйт бүсгүйгээ чөлөөлөхийн тулд тэр ч бас уналт, зовлон, доромжлол, өв залгамжлалаасаа хагацах зэрэг төлөөсүүдийг төлдөг. Хэдийгээр зуурдын томоохон уналтууд тохиох ч гэсэн түүний алдрын орой руу өгсөх өгсөлт бүгдээс агуу байна. Яг л Иехова шиг Бурханы зарц болон хүү Сионы Онгон Охидтой хуримлана. Аврагчтай адил төстэй зовлон амссанаар тэд ч бас төгсгөлгүй аз жаргалыг хүртэнэ.

Бурханы зарц болон хүүг эсэргүүцэгчид нь эзлэн түрэмгийлэгч Ассирийн хаан, төгсгөлийн цаг үеийн Христийн эсрэг үзэлтнүүд юм. Тэр бол үлгэрт гардаг мангас, эсвэл гол дайснуудтай ижил төстэй юм. Вавилоны Харлот бол шулам эсвэл ёс бус хойд ээжтэй адил зүйрлэгдсэн ба Сионы Охидыг эсэргүүцэгч тэд юм. Аврал ирэхэд сахиусан тэнгэрийн төлөөлөгчид нь загалмайлсан шидэт эцэг эхтэй эн тэнцүү байх болно. Тэдний бурханлаг хүч нь чөтгөрийн давалгааг эргүүлэхэд тусалдаг. Төгсгөлд нь дэлхийн хүмүүсийн хувьд хуваагдал тохионо. Дэлхийн ихэнх хүмүүс Сионы Онгон охидыг эсэргүүцдэг царай муут өргөмөл эгч нартай адил юм. Түүнийг үзэн ядагч бүхэн мөхөн устана. Зөвхөн түүнийг хайрладаг тэд диваажингийн алдарт хүрэх дэлхийг өвлөн авна. Зөвхөн тэд л дэлхийн мянганы амар амгалангийн үед амар сайхандаа жаргах болно.